



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/72

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын  
газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл  
олгох, цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид Зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид Дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS6043:2009" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид Амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Цогт Өргөө од ХХК-ний "Цогтбаян" зочид буудлын 16/071, Комо юнайтед инк ХХК-ний "Сайн өдөр" зочид буудлын 15/077, Амури оргил ХХК-ний "Гранд хилл" зочид буудлын 15/078, Цоглог хангай ХХК-ний "Очир титэм" зочид буудлын 14/001, Манкур ХХК-ний "Манкур" дэн буудлын 15/085, Иргэн П.Амардэлгэрийн "Ундрал" дэн буудлын 16/059, Оасисмон ХХК-ний "Оасисмон" дэн буудлын 16/064, Ди Эс Би Эс ХХК-ний "Евро" дэн буудлын 15/256, Хүрхрээ тур ХХК-ний "Хүрхрээ тур" амралтын газрын 16/012, Алтан бумба Мандал ХХК-ний "Рич Хилл" зочид буудлын 16/069, Төгөлгоо ХХК-ний "Бурхант төв" зочид буудлын 15/076, Сэлбэ Оюу ХХК-ний "Сэлбэ Плаза" зочид

1150590280

буудлын 13/176, Батхаан групп ХХК-ний “Батхаан” зочид буудлын 16/094 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

5. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага болон иргэн тус бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.

6. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

7. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Отгонсүвд/-д үүрэг болгосугай.

ДАРГА *Д.Батсүх* Д.БАТСҮХ



Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2017 оны 09 сарын 06  
өдрийн Дугаар тушаалын нэгдүгээр  
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2017.09.26

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Цогт-өргөө од ХХК	2857405	Цогтбаян	СХД-ийн 11-р хороо Цагдаагийн гудамж-43
2	Цоглог хангай ХХК	2542811	Очир титэм	БГД-ийн 7-р хороо Энэр төвийн байр
3	Амури Оргил ХХК	5378125	Гранд хилл	БГД-ийн 18-р хороо Жалханз хутагт Дамдинбазарын гудамж-52
4	Комо юнайтед инк ХХК	2772515	Сайн өдөр	БГД-ийн 8-р хороо Дилав хутагт жамсранжавын гудамж
5	Батхаан групп ХХК	2027968	Батхаан	БГД-ийн 1-р хороо Замчдын гудамж-37
6	Сэлбэ Оюу ХХК	5701694	Сэлбэ Плаза	БГД-ийн 5-р хороо 10-р хороолол ЭТӨЧ 89/01
7	Төгөлгоо ХХК	5528658	Бурхант төв	БГД-ийн 22-р хороо Зүүн нарангийн-61
8	Алтан Бумба Мандал ХХК	5202809	Рич Хилл	БГД-ийн 7-р хороо Дилав хутагт Жамсранжавын гудамж- 51,51/1

--ooOoo--

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2017 оны 08 сарын 06  
өдрийн АТЭ дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2017.09.26

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Иргэн П.Амардэлгэр	ЦЕ69012301	Ундрал	БЗД-ийн 18-р хороо Намъяанжугийн гудамж-20
2	Оасисмон ХХК	5678714	Оасисмон	БЗД-ийн 12-р хороо Чулуутын 1-10
3	Ди Эс Би Эс сервис ХХК	5373697	Евро	СХД-ийн 17-р хороо 1-р хороолол 18032, Москвагийн гудамж-55
4	Манкур ХХК	2881039	Манкур	БГД-ийн Туулын 19-386

---ooOoo--

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2017 оны 09 сарын 06  
өдрийн 87 дугаар тушаалын  
гуравдугаар хавсралт



АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2017.09.26

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Континентал ХХК		Континентал	БЗД-ийн 20-р хороо Бага улиастайн ам
2	Номадстурс экспедишн ХХК	2073226	Туул риверсайд лодже	БЗД-ийн 20-р хороо Гачуурт тосгон майхан толгой
3	Оршил гранд ХХК	5660955	Оршил ресорт	БЗД-ийн 20-р хороо Шар хоолойн аманд
4	РЭАБ ХХК	5496802	Говь люкс	БЗД-ийн 20-р хороо Даваатын ам
5	Хүрхрээ тур ХХК	2714639	Хүрхрээ тур	БЗД-ийн 11-р хороо Залаатын зүүн богины ам
6	Хишиг Арвин ХХК	2692309	Хишиг монгол	ХУД-ийн 14-р хороо Богдхан уулын түргэний ам
7	Цогт хангайн од ХХК	6072453	Цогт хангайн од	ЧД-ийн 17-р хороо Зуслангийн задгай

--ooOoo--